

**“ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ, ЖАГСААЛТ, ЖУРАМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ”  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛЫН  
ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

**2024 оны 10 дугаар сарын 1**

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн дагуу Эрүүл мэндийн даатгалын Ерөнхий газар нь Эрүүл мэндийн даатгалын сангийн батлагдсан төсөвт багтаан, иргэн даатгуулагчдын эрүүл мэндийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, эмнэл зүйн хувьд үр дүнтэй, эдийн засгийн хувьд үр ашигтай тусламж, үйлчилгээг худалдан авах замаар иргэн даатгуулагчдын хүртээмжтэй, чанартай тусламж, үйлчилгээ авах эрхийг хангах, улмаар эрүүл мэндээс үүдэлтэй санхүүгийн эрсдэлээс хамгаалах бодлогыг баримталж ажилладаг.

ЭМДЕГ-ын зүгээс ЭМДҮЗ-ийн баталсан дүрэм, журмуудыг мөрдлөг болгох, хэрэгжилтэд үнэлгээ хийж, тасралтгүй сайжруулах арга хэмжээг авч ажиллаж байна. Эрүүл мэндийн даатгалын хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.6 дахь заалтын дагуу Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар нь 2020-2024 онуудад Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолоор эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний жагсаалтыг шинэчлэн баталж мөрдүүлсэн бөгөөд энэ удаад 6 дахь өөрчлөлтийн хувилбарыг боловсруулан хүргүүлж байна.

Жагсаалт, журмыг шинэчлэн боловсруулахдаа Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны батлагдсан төсөвт багтаан үр ашигтай зохион байгуулах үүднээс нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний хүртээмжийг орон нутагт нэмэгдүүлэх, төвлөрлийг сааруулах, амьдралын чанарыг дээшлүүлэх, төлөвлөгөөт хэлбэрээр үзүүлэх боломжтой тусламж, үйлчилгээний тоо хэмжээг зохистой түвшинд хязгаарлаж тоо хэмжээг хэт өсгөх биш, чанартай, үр дүнтэй тусламж, үйлчилгээг бий болгоход чиглэж стратегийн худалдан авалтын бодлогыг тусгасан болно.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн дагуу иргэн, даатгуулагчдын эрэлт хэрэгцээнд нийцсэн тусламж, үйлчилгээг худалдан авах ба тусламж, үйлчилгээний тоо хэмжээг нийт болон эрүүл мэндийн байгууллага тус бүрээр тооцоолж төлөвлөсөн.

Төрийн албан хаагчдын цалин хөлсийг инфляцийн түвшинтэй уялдуулан 6 хувиар нэмэгдүүлэхээр Улсын Их хуралд өргөн мэдүүлсэн бөгөөд 2025 оны төсвийн төсөлд тусгасан. Иймд эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн сүлжээг шинэчилсэн үед эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний суурь тарифын хэмжээг шинэчлэн тогтоох заалтын дагуу тусламж, үйлчилгээний суурь тарифыг 2 хувиар нэмэгдүүлсэн болно. Шаардлагагүй хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээг бууруулах, амбулаторийн тусламж, үйлчилгээг нэмэгдүүлэх, иргэн, даатгуулагчид эрүүл мэндээс шалтгаалсан санхүүгийн эрсдэлээс сэргийлэх зорилгоор хамтын төлбөрийн дээд хязгаарыг тогтоож, санхүүгийн эрсдэлтэй иргэнээс төлөх хамтын төлбөрийг хувьчилж бууруулах тохируулгыг хийхээр төлөвлөсөн болно. Иймд эрүүл мэндийн байгууллагуудаас хамтын төлбөрийн бодлогыг ямар тусламж, үйлчилгээн дээр, хэрхэн хэрэгжүүлэх талаар санал ирүүлэх нь чухал ач холбогдолтой болно.

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР**